# ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ, ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ, ИРГЭДТЭЙ ХАРИЛЦАХ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХТУЯАГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВЧ ШИЙДВЭРЛЭХ БОЛОН ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ХЭРЭГЖИЛТЭНД ХЯНАЛТ, ТАЙЛАГНАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг аль болох богино хугацаанд /хуулинд заасан хугацаанд багтаан/ шийдвэрлэж хариу өгөх | Өргөдөл,гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа | 9.6 | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 9.5 өдөр болгоно. | Тайлангийн хугацаанд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий байгууллага, ажилтанд нийт 2767 өргөдөл, гомдол ирсний 156 буюу 5.6 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 2611 буюу 94.4 хувь нь хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэгдлээ. Ирсэн өргөдөл, гомдлын 72 нь гомдол, 65 нь талархал,8 нь санал, 2622 нь хүсэлт байна.<br>Ирсэн нийт өргөдөл, гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд орлогод нийцсэн орон сууц хүссэн 38.8 хувь, газрын харилцааны асуудлаар 8.4 хувь, нийгмийн халамжийн төрөл бүрийн үйлчилгээ авахыг хүссэн 6.8 хувь, халаалт цэвэр бохир ус шугам хоолойтой холбогдолтой асуудлаар 6.7 хувь, барилгын асуудлаар 3.6 хувь, нийтийн аж ахуйн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 3.1 хувь, нийтийн тээврийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 2.8 хувь, боловсролын салбарын үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 2.1 хувь, нийгмийн даатгалын салбарын асуудлаар 1.9 хувь, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбогдолтой асуудлаар 1.8 хувь эдгээр өргөдлүүд нийт өргөдлийн 76.0 хувийг эзэлж байна.Үүнээс: Аймгийн ЗДТГ-т тус төвд нийт 776 өргөдөл, гомдол ирснээс 100 хувь хуулинд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн. Тус төвд ирж буй өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай | 2025.01.01-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.Аймгийн ЗДТГ-т ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9.5 хоног байна. | | |
| 2 | Өргөдөл гомдлын цахим системд өргөдөл, гомдлыг бүрэн бүртгэж шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг оруулах | Хэрэгжилтийн хувь | 100% | Хэрэгжилт 45-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна | Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газарт нийт 776 өргөдөл,гомдол ирснийг өргөдөл, гомдлын цахим системд 100 хувь бүртгэн шийдвэрлэлтэнд хяналт тавьж, хугацаа хэтрүүлсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж, удирдлагад танилцуулан ажилласан. Дээрх нийт өргөдлийн 314 нь бичгээр, 29 нь цахимаар, 53 нь 11-11 төвөөс, 377 нь утсаар, 3 нь биечлэн уулзаж ирүүлсэн бөгөөд 100 хувь хуулийн хугацаандаа шийдвэрлэгдсэн байна. Орхон аймгийн иргэд IRGEN.ERDENET.MN вэб системийг ашиглаж Цахимаар төрийн аль ч байгууллагад илгээж шийдвэрлэлтийг иргэд хянах боломжтой болсон. | 2025.01.01-2025.12.31 | 100% |
| 3 | Төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллах | Хамрагдсан байгууллагын тоо | 28 | 28 төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол хуулинд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн байна. | Аймгийн Засаг даргын 2025 оны А/257 дугаар захирамжаар байгуулагдсан Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгээс 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс 04 дүгээр сарын 22-ны өдрийн хугацаанд аймгийн Засаг даргын дэргэдэх төрийн захиргааны байгууллагуудад 2024 онд иргэдээс Жаргалант, Баян-Өндөр сумын ЗДТГ, 28 төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний байдалтай танилцан хяналт шинжилгээ үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Хяналт шинжилгээ үнэлгээний явцад ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэнд тавих хяналтыг сайжруулах. www.irgen.erdenet.mn сайтын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангалтгүй байгаа тул цаашид багуудын цахим булангийн үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулан холбогдох арга хэмжээ авч хэрэгжилтийг ханган ажиллах талаар 28 байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан ажилтанд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав. | 2025.03.01-2025.05.01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Нутгийн захиргааны байгууллагуудад ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэх. | Тоо | 4 удаа | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг үнэн, зөв гаргаж, хуулийн хугацаанд 2 удаа холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Нутгийн захиргааны байгууллагуудад ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт улирал тутам тайланг үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд хүргүүлж байна. | 2025.03.25-2025.12.31 | 100% |
| 5 | Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирж байгаа өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдлыг сайжруулах шийдвэрлэлтийн хугацааг бууруулах | Өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа | 10.6 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 10.5 өдөр болгоно. | Засгийн газрын 11-11 төвөөс ирүүлсэн чиглэлийн дагуу өргөдөл,гомдлыг нэн даруй ажлын 5 хоногт багтаан яаралтай шийдвэрлэж ажиллах талаар байгууллагуудад үүрэг чиглэл өгч, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажилласнаар тус төвөөс ирүүлсэн 53 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног болж буурсан байна. | 2025.01.01-2025.12.31 | 100% |
| ХОЁР. “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ.” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, сурталчлах, тэдний санал хүсэлтийг авч шийдвэрлэх зорилоор аймгийн хэмжээнд “Нээлттэй хаалга”-ны өдрийн зохион байгуулах | Тоо | 33 байгууллага 2-3 удаа зохион байгуулсан. | 33 байгууллагууд Нээлттэй хаалганы өдөр 1 удаа зохион байгуулсан байна. | Тайлант хугацаанд төрийн болон төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч 33 байгууллагаас Нээлттэй хаалганы өдөрлөгийг 1-2 удаа зохион байгуулан давхардсан тоогоор 3000 гаруй иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч, төрийн үйлчилгээ авахад шаардлагатай 1600 гаруй сурталчилгааны материал тараасан. Иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, төрөөс болон орон нутгаас гаргаж буй бодлого, шийдвэр, арга хэмжээнүүдийг олон нийтэд танилцуулж, сурталчлан ажиллалаа. Нээлттэй өдөрлөгийн үеэр иргэдээс нийт 183 иргэний | 2025.01.01-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санал хүсэлтийг хүлээн авч газар дээр нь шийдвэрлэсэн.<br>Орхон аймагт 1 жилийн хугацаанд зохион байгуулагдах олон нийтэд чиглэсэн арга хэмжээний календарчилсан төлөвлөгөөнд тусгуулахаар 4 хэлтэс, 21 байгууллагаас 108 арга хэмжээний санал ирүүлснийг нэгтгэн Хамтын ажиллагаа, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр хариуцсан удирдагчид хүргүүлсэн. | | |
| 2 | Аймгийн тайланг иргэдэд тавих ажлыг зохион байгуулах, өмнөх оны ажлын тайлан тавих үеэр гарсан санал шүүмжлэлийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж тайлагнах. | Тоо | 2 удаа | Иргэдээс гарсан санал шүүмжлэлийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж, иргэдэд 1 удаа тайлагнана. | УИХ-ын гишүүд Орхон аймагт ажиллах үеэр иргэдээс ирүүлсэн нэр бүхий 22 иргэний гэр хүссэн-3, хүлэмж хүссэн-1, санхүүгийн дэмжлэг хүссэн-3, ажлын байр хүссэн-1, орон сууц хүссэн-1, хэрээсний машин хүссэн-1, Хүлэг худалдааны төвийн түрээсийн төлбөр нэмэгдсэн зэрэг 30 гаруй асуудлаар гаргасан хүсэлтүүд, мөн Уртын гол, Баянцагаан, Малчин, Цагаанчулуут баг болон, Дэнж, Эрдэнэ, Даваат багийн иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг холбогдох хэлтсүүдэд хүргүүлэн биелэлтийг нэгтгэн гаргаж, УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа, Л.Энх-Амгалан, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар нарт хүргэх ажлыг зохион байгуулсан. | 2025.01.01-2025.12.31 | 100% |
| 3 | Аймгийн Засаг дарга 7 хоног бүрийн Пүрэв гарагт иргэд хүлээн авч уулзаж, Баасан гарагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхээр холбогдох газар, хэлтсийн хамт газар дээр нь ажиллахад уулзалтын тэмдэглэл хөтөлж, Засаг даргаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу төлөвлөгөө | Тоо | 8 удаа | 24 удаа | Засаг дарга 7 хоног бүрийн пүрэв гарагт 19 удаагийн уулзалтаар 200 гаруй иргэдийг хүлээн авч уулзан аймаг, орон нутгийн хөгжил, тулгамдаж буй асуудлын талаарх санал, хүсэлтийг нь сонсож газар дээр нь шийдвэрлэх арга хэмжээ авч холбогдох хэлтэс, байгууллагад 321 үүрэг даалгавар өгч ажилласан байна. Үүнээс биелэлтийг тооцож үзвэл:100 хувийн биелэлттэй 269, 60-90 хувийн биелэлттэй 16, 30-50 хувийн биелэлттэй 31, 0-20 хувь буюу биелэлт хангалтгүй 5 үүрэг даалгавар байна.<br>Мөн иргэдийн санал, хүсэлтийн дагуу тулгамдсан 71 асуудлаар газар дээр нь очиж танилцан холбогдох хэлтэс, байгууллагуудад нийт 94 үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан тухай бүр мэдээлэл бэлтгэн шуурхай хурал, хэвлэл мэдээллийн хэрэгслээр | 2025.01.01-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гарган холбогдох газруудад хүргүүлэн биелэлтийг 7 хоног бүр Засаг даргад танилцуулах, мэдээллийг аймгийн Засаг даргын шуурхай, аймгийн ЗДТГ-ын шуурхай хурлуудад мэдээллэх | | | | түгээн ажиллаж байна. Засаг даргын гадуур ажиллах үед өгөгдсөн 94 үүрэг даалгаврын биелэлтийг тооцож үзвэл: 100 хувийн биелэлттэй 54, 60-90 хувийн биелэлттэй 15, 30-50 хувийн биелэлттэй 18, 0-20 хувь буюу биелэлт хангалтгүй 7 үүрэг даалгавар байна. Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалт, гадуур ажилласан ажлын өгөгдсөн үүрэг даалгаврыг холбогдох байгууллагуудад хүргүүлэн, биелэлтийг нэгтгэн 7 хоног бүр Засаг даргад танилцуулан, хэрэгжилтэнд хяналт тавин биелэлтийг тооцон ажиллаж байна. | | |
| 4 | Төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний бүрдүүлэх материал, төлбөр хураамж, түүний төлөх данс, төлбөр хураамжийн эрх зүйн үндэслэл, хариуцах албан тушаалтны мэдээлэл бүхий судалгааг байгууллагуудаас нэгтгэж гаргах | тоо | - | Судалгааг жилд 1 удаа шинэчилж гаргана | Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны ХЭГ/454 дугаартай албан бичиг, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын 2025 оны 01/361 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Орхон аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төрийн чиг үүрэг бүхий нийт 30 байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа зөвшөөрөл болон цахим үйлчилгээнд шилжсэн үйлчилгээний талаарх 406 үйлчилгээний мэдээлэл судалгааг 2 удаа авч нэгтгэн хүргүүлсэн. | 2025.01.01-2025.12.31 | 100% |
| 5 | Багууд дээр ажиллаж байгаа цахим булангийн ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдийн санал, хүсэлтийг цахимаар гаргадаг www.irgen.erdenet.mn вэб сайтын ашиглалтын талаар иргэдэд сурталчлах талаар зохион | тоо | 1 удаа | 2 удаа | Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлээр багуудын цахим булангийн ашиглалтыг нэмэгдүүлэх, www.irgen.erdenet.mn вэб сайтын ашиглалтыг сайжруулах иргэдэд сурталчлах арга хэмжээ авч ажиллах талаар ирүүлсэн чиглэлийг Баян-Өндөр, Жаргалант сумдад аймгийн ЗДТГ-ын 2025 оны 04/151 дугаар албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин, ажилласнаар тус вэб сайтад 532 өргөдөл,гомдол ирүүлсэн байгаагаас авто зам засварлах асуудлаар 90, цахилгаан,гэрэлтүүлгийн асуудлаар 63, хог хаягдлын асуудлаар 52, ус,дулаан хангамжийн асуудлаар 46, нийтийн тээврийн | 2025.01.01-2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх | | | | үйлчилгээний асуудлаар 36, СӨХ-дын үйлчилгээний талаар 27 өргөдөл,гомдол ихээр ирсэн бөгөөд холбогдох байгууллагууд хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн иргэнд хариу мэдэгдэн ажилласан байна. | | |
| ГУРАВ. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Хэрэгжилтийн хувь | 2024 онд 100 хувь | Хэрэгжилт 45-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй байна. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа 100 хувь хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2025.02.01-2025.12.31 | 100% |
| 2 | Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан | Хугацаа | 2024 оны 2 дугаар сарын 15-ны дотор хуулийн | 2025 оны 2 дугаар сарын 15-ны дотор хуулийн хугацаанд хүргүүлнэ. | 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв гаргаж хуулийн хугацаанд мэдүүлсэн. | 2025.01.01-2025.02.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хугацаанд үнэн зөв мэдүүлэх | | хугацаанд хүргүүлсэн. | | | | |
| 3 | Хөтлөгдөж дууссан баримт бичгийг албан архив, албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу цэгцэлж байгууллагын архивт хүлээлгэн өгөх. | Баримтын тоо | 21 | 20-30 архивын баримтыг заврын дагуу цэгцэлж хүлээлгэн өгсөн байна. | Хөтлөгдөж дууссан баримт бичгийг албан архив, албан хэрэг хөтлөлтийн заавриын дагуу цэгцлэх ажлыг хийж байна. | 2025.01.01-2025.12.31 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/Д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Аймгийн Засаг даргын захирамж, Аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэгт орж ажиллах. | Зохион байгуулсан арга хэжээний тоо | - | 1 | Аймгийн Засаг даргын захирамж, Аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар батлагдсан 6 ажлын хэсэгт орж ажилласан. | 2025.01.01-2025.12.31 | 100% |
| 2. | Засаг даргын шуурхай зөвлөгөөн болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх | Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаварын тоо | - | Үүрэг даалгаварын биелэлтийн хувь | Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас 1, Аймгийн Засаг даргын шуурхай хурлаас 2, аймгийн ЗДТГ-ын шуурхай хурлаас 7 үүрэг даалгавар болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хугацаанд 100 хувь биелүүлж тайлагнасан. | 2025.01.01-2025.12.31 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Шинээр батлагдан гарсан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шаардлагатай хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаандаа ашиглах. | Тоо | 3 | 7 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Автотээврийн тухай хуулинд орсон нэмэлт,өөрчлөлт, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулинд орсон нэмэлт, өөрчлөлт, Зөрчлийн тухай хуулинд орсон нэмэлт өөрчлөлт, Авлигын эсрэг хуулинд орсон нэмэлт, өөрчлөлт, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, Газрын тухай хуулинд орсон нэмэлт өөрчлөлт зэрэг 7 хууль тогтоомжтой танилцаж ажилдаа мөрдлөгө болгон хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2025.01.01-2025.12.31 | 100% |
| 2 | Эрхэлсэн ажлын чиглэлээр зохион байгуулагдаж буй сургалтанд хамрагдах. | Сургалтын тоо-гүйцэтгэлээр | 1 | Тухай бүр хамрагдсан байна. | Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сертификаттай сургалтанд 2025 оны 01 дүгээр сарын 30-наас 05 дугаар сарын 08-ны хугацаанд хамрагдаж амжилттай суралцаж төгссөн. | 2025.01.01-2025.12.31 | 100% |
| 3 | Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног тутамд цахимаар зохион байгуулдаг сургалтанд хамрагдах | Тоо | Жилийн турш | 20-25 удаа | 2025 онд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдсан 7:4:10 цахим сургалтанд 2 удаа хамрагдсан.<br>Байгууллагаас зохион байгуулагдсан сургалтуудад тухай бүр хамрагдсан | 2025.01.01-2025.12.31 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ, ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ, ИРГЭДТЭЙ ХАРИЛЦАХ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН | ................................ / Г.ЭНХТУЯА / | 2025.06.05 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |